

## Ж.РОУЛС УТИЛИТАРИЗМЫГ ШҮҮМЖИЛСЭН НЬ

*Б.Мөнхжавхлан, доктор (Ph.D)*

*Э.Янжинлхам, магистрант*

*МУИС, Философи, шашин судлалын тэнхим*

*Түлхүүр үг: Зүй ёс, шударга ёс болсон зүй ёс, үл мэдэхийн хөшиг*

Орчин үеийн улс төрийн философи, либерал онолын хөгжилд Ж.Роулс зүй ёс хэмээх ойлголт боловсруулан, шинэ зарчим, хандлага гаргаж ирснээрээ нийгэм, эдийн засгийн бодлого, эрх зүй гэх мэт олон мэдлэгийн талбарт чухал хуудсыг нээсэн юм. Түүний үзэл баримтлал “Зүй ёсны онол”, “Улс төрийн либерализм” хэмээх алдартай хоёр бүтээлд нь тусгалаа олсон байдаг. Нийгэмд зарим хүмүүс эдийн засаг, улс төрийн хувьд эрх чөлөө, сонголтыг өргөн хүрээнд эдэлж, хэрэгжүүлж байхад зарим хамгийн бага аз завшаантай хүмүүс тийм эрх, боломжийг эдэлж чаддаггүй. Тэрээр “Сэтгэлгээний системд үнэн гэдэг гэдэг ойлголт эрхэм байдгийн адил, зүй ёс гэдэг ойлголт нийгмийн институцэд анхдагч эрхэм чанар байдаг. Онол хэдий сэтгэл татам, хэмнэлттэй байдлыг илэрхийлэвч үнэн биш бол үгүйсгэх эсвэл засварлах ёстой. Үүний нэгэн адил хууль, институци шударга бус байвал хэдий үр дүнтэй, сайн зохион байгуулалттай байсан ч шинэчлэх эсвэл тэдгээрийг устгах ёстой. (Rawls, 1999, p. 3)” гэж үзсэн юм. Роулсын үзэж байгаачлан зүй ёс хэмээх нийгмийн эрхэм чанар нь ардчилсан нийгэмд бол хувийн ашиг сонирхолтой бас рационал хувь хүмүүс болохынхоо хувьд ашиг сонирхлоо хамгаалахын тулд ёс суртахууны императивийн дагуу үйлдэж буй эрх тэгш бас чөлөөт хүмүүсийн зөвшилцлийн үр дүн байдаг (Нийгэм-улс төрийн философийн орчин үеийн онолууд, 2023, хууд. 63). Түүний энэ үзлийг “зүй ёс” хэмээх үгээр нь тайлбарлавал институц нийгмийн хамтын ажиллагаанд эрх, үүрэг, үр ашгийг шударга

байдлаар хуваарилах тухай асуудал мөн (Edward, 2016). Энэ санаа түүний зүй ёсны онолын гарааны цэг юм.

Роулс ардчилсан нийгэм, эрх чөлөө, аз жаргал, эдийн засгийн хөгжил гэх мэт олон үнэт зүйлийн дундаас зүй ёсыг нэн тэргүүнд тавихыг эрхэмлэж байжээ. Түүнийхээр зүй ёст нийгэм гэдэг бол хүн бүр нийгмийн байр суурь, хувь хүний шинж чанарыг эс харгалзан үндсэн тэгш эрхээ эдэлж болох тийм нийгэм мөн. Тэр эрх нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, холбоо байгуулах зэрэг улс төр нийгмийн суурь эрхүүдийг багтаана. Эдгээр суурь эрхийг үндсэн хуулиар баталгаажуулах нь чухал ажээ. Зүй ёст нийгэмд төр, бүх иргэдийн үндсэн эрхийг нь хамгаалах, хүн эрх чөлөөгөө эдлэх эдийн засгийн болон нийгмийн нөхцлийг нь бий болгох үүрэгтэй. Үүнийг ч бид өдгөө эдийн засаг, нийгэм, улс төрийн эрхийн хүрээнд мэдэх билээ. (ЭЗНСЭ-ийн тухай Олон Улсын Пакт) Энэ нь нийгмийн сайн сайхны төлөө болон эдийн засгийн тэгш бус байдлыг буруулахад засгийн газрын үүргийг хэлэлцэхэд чухал үндэслэл болдог. Тэрээр энэ онолдоо тэгш эрх, эрх чөлөө хоёрыг аль болохоор зохицуулах оролдлого хийсэн юм. Шударга ёс хэрэгжих нөхцөл нь хүн бүр тэгш боломж хүртэх шударга шийдвэрийг баталгаажуулсан институцууд, дүрмүүдийн тогтолцоог шаарддаг. Тэгэхээр зүй ёс, шударга ёс гэдэг бол Роулсын онолын хувьд хамгийн гол ойлголт болох төдийгүй нийгмийн буюу институтын утгыг илэрхийлж байна. Үүнийгээ тодруулахдаа тэрбээр “бидний хувьд зүй ёсны үндсэн субъект бол

нийгмийн үндсэн бүтэц буюу нийгмийн томоохон институциуд үндсэн эрх, үүргийг хэрхэн хуваарилж, нийгмийн хамтын ажиллагааны давуу талыг тодорхойлж буй арга юм. Томоохон институциуд гэдэг нь улс төрийн үндсэн хууль, эдийн засаг, нийгмийн үндсэн зохицуулалт мөн. Тиймээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хууль ёсны дагуу хамгаалах, өрсөлдөөнт зах зээл, үйлдвэрлэлийн хэрэгсэл дэх хувийн өмч, моногами гэр бүл нь нийгмийн томоохон институциудын жишээ юм (Rawls, 1999, хууд. 7)” гэжээ. Гэхдээ тэрээр үүнийгээ зөвхөн дээрх институциын болон төр, улс орнуудын хоорондын хуулийн харилцаагаар хязгаарлаагүй байна.

Роулс онолоо ёс зүйн чухал онолуудыг шинжлэн үзсэний үндсэн дээр боловсорсон байдаг. Тухайлбал Кантын үзэл баримтлал, утилитаризмын үндсэн санаа түүний үзэл бүрэлдэхэд нөлөөлсөн бөгөөд энэхүү өгүүлэлд Ж.Роулсыг зүй ёсны тухай үзэл баримтлалаа дэвшүүлэхдээ утилитаризмд хэрхэн шүүмжлэлтэй хандсан тухай авч үзэж байна. Роулс утилитаризмыг шүүмжилсэн шалтгаан нь мөнөөх эрх, үүрэг, үр ашгийг шударга байдлаар хуваарилах тухай асуудал мөн. Шударга хуваарилалтын талаар ялгаатай үзэл санаанууд бий. Хэн нэгэн хүн институци нь А-гийн боловсруулсан, эсвэл Б-гийн...эсвэл гэх мэт дүрэмд гэх мэт захирагдаж байвал зүй ёс хэрэгжиж байна гэж үзнэ. Роулс эдгээр санал зөрөлдөөнийг шийдэхийг зорьсны нэг нь утилитаризмд хандсан явдал юм. Тухайлбал Айвар Лабүкт бичихдээ Роулсын утилитаризмд хандсан байр суурийг үнэлж дараах гурван асуудлаар илэрхийлсэн (Labukt, 2009). Утилитаризмын хэрэгжих боломжийг шүүмжилбэл: (1) улс төрийн хувьд ажиллах боломжтой гэж үзэхэд санал зөрөлдөөн маш их гарна, (2) утилитар нийгэм, нийгмийн тогтворгүй байдлын өмнө хүчин мөхөс байна (3) утилитари зарчмыг зөв, буруугийн эцсийн шалгуур болгон олон нийтийн хувьд баримтлах нь зарим иргэдийн өөрийгөө хүндлэх

хүндлэлийг унагах болно гэсэн байдаг. Тэрээр энэ үндэслэлийг тайлбарлахдаа, 1. Утилитари улс төрчид түүхэн туршлага, хоёрдогч зарчмууд, эмпирик шинжлэх ухаануудын янз бүрийн ерөнхийлөлд түшиглэж байдаг. Энэ үүднээс утилитар үзэл амжилттай хэрэгжих боломжгүй. Гэхдээ үүгээрээ Роулс сайн сайхан байдлыг дэмжих утилитаризмын үзэл санааг шууд үгүйсгээгүй. Харин түүнийхээр хэрэв бүгд, бүх стратегийг хүлээн зөвшөөрсөн үед үр дүнтэй байж болох ч зөвшилцөл алдаа дутагдалтай. Иргэд өөрсдийнх нь сонирхлын төлөөх бодлогыг л дэмжих хандлагатай тул аль нь сайн үндэслэгээ байна вэ гэдгийг шийдэх тодорхой процедур байхгүй. Иймд утилитари улс төр зөрчлөөр дүүрэн байх болно гэсэн байна. Харин зүй ёсны зарчим илүү тодорхой, хэрэгжих боломжтой гэж үзжээ. 2. Утилитаризм, тогтвортой нийгмийг баталгаажуулахад хангалттай дэмжлэг үзүүлж чадахгүй гэсэн. Учир нь уг үзэл нь олонхийн сайн сайхны төлөө цөөнхийн эрх ашгийг эс тоомсорлодог нь, мөн энд төр эрх мэдлээ хэтрүүлэх нь таагүй байдлыг үүсгэдэг гэсэн санааг илэрхийлсэн. Үл мэдэхийн хөшигний араас харахад утилитар хандлага дахь эрх мэдэл, хүчийг ашиглах нь ёс суртахууны хувьд эрсдэлтэй гэж үзсэн 3. “Өөрийгөө хүндлэх” гэдэг үгээр Роулс хүн өөрийн зорилго, амьдралын төлөвлөгөөгөө биелүүлж чадна гэдэгт итгэх итгэл үнэмшлийг хэлдэг.

Тэрээр өөрийгөө хүндэтгэх нь “магадгүй хамгийн чухал сайн сайхан зүйл, учир нь үүнгүйгээр юу ч хийж байсан үнэ цэнэтэй санагдахгүй, эсвэл зарим зүйл үнэ цэнэтэй байдаг бол тэрний төлөө хичээх хүсэл зоригоор дутагдах болно (Labukt, 2009)” гэж үздэг. Утилитари нийгэмд тодорхой хүмүүс ийм итгэлээ алдаж болзошгүйг энд сануулсан байна. Оронд нь тэрээр ёс суртахууны болон авьяас, төлөвлөгөөнд суурилсан өөрийгөө хүндэтгэх хүндлэлийг авч үзсэн шударга ёс болсон зүй ёсны тухай санааг гаргаж ирсэн ажээ. Дэвид

Лионс, Роулсын үзэл дэх ялгаатай байдлын зарчимд суурилан утилитаризмын асуудлыг авч үзэхдээ “нийгмийн тэгш бус байдлыг зөвхөн хүн бүр тэндээс үр өгөөжийг нь хүртэх тохиолдолд зөвшөөрч болно: хэрэв хэн нэгэн бусдаас дор байвал, тэр нь тэгш бус байдалгүйгээр байснаас илүү сайн байгаа бол зүй ёс байна (Lyons, 1972) хэмээн Роулсын үзлийг онцолсон байна.

Түүний зүй ёсны онол утилитаризмд зөрчилдөх дараагийн шалтгаан нь утилитари зарчимд бий. Энэ онолын гол төлөөлөгч Жон Стюарт Милль (1806-1873) нийгэм хэдий чинээ олон хүнд аз жаргал өгч байна, мөнхүү аз жаргал хэдий удаан үргэлжилж байна тэр хэмжээгээр нийгэмд зүй ёс байна гэж үзсэн. Мөн сэтгэл ханамж авч чадаж байвал тэгш бус байдлыг ч хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж байв. Энэ утгаар бол утилитари үзэл аз жаргалыг нэмэгдүүлж байвал ямар ч төрлийн тэгш бус байдлыг хүлээн зөвшөөрч байгаа юм. Нийтийн сайн сайхан хийгээд аз жаргалыг эрхэмд үзсэнээрээ энэ үзэл хүмүүсийн ялгаатай байдал, өөр өөр сонголт хийх боломжийг үгүйсгэдэг гэж Роулс шүүмжилдэг. Тэр шүүмжээ “анхдагч байр суурийн” үүднээс эхлүүлдэг. Роулс анхны байр суурин дээрээ байгаа хувь хүмүүст тодорхой альтернатив сонголт байгаа гэж үзвэл утилитари зарчмын оронд эрх чөлөөний зарчмыг санал болгосон. Хүн бүр тэгш эрхтэй байх ёстой. Үндсэн эрх чөлөө нь: улс төрийн эрх чөлөө буюу сонгох эрх, үзэл бодлоо илэрхийлэх; эвлэлдэн нэгдэх, хувийн өмчтэй байх эрх; дур зоргоороо баривчлахаас ангид байх эрхтэй. Энэ үүднээс харвал утилитаризмд, нийт аз жаргалыг дээд зэргээр нэмэгдүүлэхийн тулд хүнийг хүчээр боолчлох эсвэл хөнөөхийг зөвшөөрч болох нь (Edward, 2016). Гэхдээ Роулсын боловсруулсан эрх чөлөөний зарчим үүний эсрэг байж хувь хүний үндсэн эрх чөлөөг хамгаалдаг. Үүнийг анхны байр суурийн аргумент (Edward, 2016) гэж нэрлэнэ.

Роулс энд нийгмийн гэрээний онолын нэг өвөрмөц хэлбэрийг зүй ёсны тухай онолдоо тусган оруулжээ. Үндэслэлээ боловсруулахын тулд Роулс зүй ёсыг тодорхойлох зарчмуудыг сонгох гэрээ хийж буй хүмүүс бүхий таамаглалын нөхцөлийг ашигласан байна. Хүмүүст хүйс, авьяас чадвар, угсаа гарвал, арьс өнгө гээд тэгш бус байдлыг бий болгож буй ялгаатай шинжүүд байдаг нь тэрхүү эхлэлийн нөхцөл болж байдаг. Хэрэв тэд дээрх болон өөр олон шинжээр ижилссэний дүнд бий болох янз бүрийн бүлэгт өөрийгөө хамааруулан үзсээр байвал тэдний шийдвэр хүн бүрийн төлөө биш харин тодорхой нэг бүлгийн төлөө байх учраас зүй ёсны талаарх зарчмыг зөв сонгож чадахгүй. Ийм учир Роулс зүй ёсыг ямар нэг талыг баримталсан байх ёсгүй гэж үздэг (justice as impartiality). Үүний дагуу бол дээр цугласан улс үл мэдэхүйн хөшигний ардаас шийдвэр гаргах ёстой. Энэ гивлүүр бол аливаа хүнийг мөнөөх тэгш бус байдлыг үүсгэж буй бүлгүүдийн алинд нь харьяалагдахаа мэдэхгүй байхад хүргэх тийм хөшиг мөн. Ийм гивлүүрийн ардаас шийдвэр гаргах явдлыг Роулс бас анхдагч байр сууринаас (original position) шийдвэр гаргах явдал хэмээн нэрлэдэг. Хэрэв мөнөөх улс хувийн ашиг сонирхолтой, бас рационал хүмүүс бөгөөд нийгмийн ялгаатай статуст байдаг бүлгүүдийн альд нь харьяалагдахаа мэдэхгүй байгаа бол нийгмийн бүх л бүлгийг тэгш байлгаж чадах тийм зарчмуудыг сонгож таарна. Өөрөөр хэлбэл тэд аль нэг бүлэгт илүү давуу тал олгох тийм сонголтыг хийх юм бол дутуу боломж хүртэж буй тэр бүлэгт өөрсдөө ч орчихсон байх эрсдэлтэй юм. Тийм бол бүх л бүлэгт тэгш боломж олгох нь хэлэлцээрт оролцож буй хүмүүсийн хувийн ашиг сонирхлын үүднээс хамгийн рационал сонголт байх болно. Роулс ийм анхдагч байр суурь бүхий нөхцөлийг үзээд зүй ёсны хоёр зарчмыг боловсруулжээ.

Үүний эхнийх нь хүмүүсийн суурь эрх чөлөөний тэгш байдлын тухай зарчим бол удаах нь нийгэм, эдийн засгийн

тэгш бус байдлыг хэрхэн зохицуулахтай холбогдох зарчим юм. Хүн бүр бусад хүнд буй өөрийнхтэй нь ижил эрх чөлөөний схемтэй нийцтэй байх боломжит хамгийн өргөн хүрээ бүхий тэгш бөгөөд суурь эрх чөлөөний схемтэй байх эрхтэй (Rawls 1999, 53). Тухайлбал Роулсын боловсруулсан ялгаатай байдлын зарчим нь хамгийн бага аз завшаантай хүн хүртэл боломж хүртэх тухай асуудал байгаа нь нийгмийн бүх гишүүд гэрээнд оролцдог гэсэн санаа юм.

Тэрээр хэдий хувь хүний эрх чөлөөг абсолют утгаар авч үзээгүй ч үүний оронд нийгмийн бүх хүмүүст тэгш боломжийг гаргаж ирэхийг илүүд үзсэн байна. Роулс мөн эрх чөлөөний тухай ойлголтыг утилитаризмд харьцуулсан. Түүний боловсруулсан эрх чөлөөний зарчмын үндсэн санаа бол иргэн бүрийн эрх чөлөө бусад бүх хүмүүсийн эрх чөлөөтэй адил байх явдал байдаг. Энэ нь бүх хүмүүст тэгш боломж олгох тухай бөгөөд тэрээр хамгийн бага давуу талтай хүмүүст хамгийн их боломж олгох Миллийн үзлийн эсрэг байв. Утилитаризм бол нийгмийг бүхлээр нь авч үзээд, нийт аз жаргалын түвшнийг нэмэгдүүлэх, хадгалах явдлыг зорилгоо болгодог учир хүмүүсийн тусгаар байдал, өөр өөр сонголт хийх боломжийг нь үл хэрэгсдэгээрээ хувь хүмүүст шударга (fair) ханддаггүйг ийнхүү тэрээр тэмдэглэсэн. Бас нийтийн сайн сайхан байдлын төлөө нэрээр цөөнхийн эрх, эрх чөлөөг үл хэрэгсдэг гэж үзсэнийг өмнөтөө дурдсан билээ. Роулсын үзэл баримтлал ёсоор баян ядуугийн ялгаа улам бүр нэмэгдэж буй байдлыг тэрээр авч үзэж, эдгээр ялгааг багасгахад чиглэсэн нийгмийн хөтөлбөрүүдийг зөвтгөдөг байна. Энэ нь сайн сайхан амьдралын тухай янз бүрийн үзэл бодлын дунд буюу зарим хүмүүс үүнийг либерал гэж үздэг, зарим төрийн мөнгийг тухайлбал шашны сургуулиудад шашны дэлгэрүүлэхэд ашиглахыг зөвшөөрдөг асуудалд таатай биш ханддаг зэрэг асуудалд төвийг сахисан байр суурь болж байдаг. Гэхдээ энд

Роулсын либерал контрактарианизм бүлэг эсвэл олон нийтийн төлөө байхаас илүү хувь хүний шийдвэр гаргахыг илүүд үздэг билээ (S.Wenz, 2007, хууд. 186). Энэ үзэл нь ч утилитаризмын талаарх түүний байр суурийг илэрхийлдэг.

Миллийн үзэлд ардчиллын суурь үндсэн элементүүдийн нэг бол олонхын эрх ашгаас ялгаатай байж болдог эрх ашгийг хөгжүүлэх явдлыг оролцуулан өөрсдийнхөө хүссэн ёсоор биеэ авч явах талаар иргэдэд олгодог олон янзын бололцоо, эдгээр эрх ашгийг хангах нөхцөл болох “бодгаль үзэл”-ийн тухай санаа бий. Тэрээр олон нийтийн санал нь сүсэг бишрэл, уламжлалт төсөөлөл зэрэгт холбоотой байж болно гэж үзээд тийм санал хууль болох ёсгүй гэж үзжээ. Зөв хөгжиж буй ардчилсан нийгэмд олон нийтийн саналын өмнө биеэ чөлөөтэй авч явах эрх бодгалийн талд байх ёстойг тэрээр сануулсан байдаг. Энэ нь дээр дурдсан өөртөө итгэх итгэлийн тухай асуудалд мөн холбогдоно.

Роулс мөн суурь бүтцийн асуудалд утилитаризмыг харьцуулж үзсэн байна. Нийгмийн гол байгууллагууд нэг системд эв зохицолтой оршиж, үндсэн эрх, үүргийг тодорхойлон, нийгмийн хамтын ажиллагааны явцад бий болсон давуу талыг хэлбэржүүлэгч арга замыг суурь бүтэц хэмээн тэрээр тодорхойлсон байдаг. Үүнд үндсэн хууль, эдийн засгийн зохион байгуулалт, гэр бүл, өмч зэрэг нь суурь бүтэцэд хамаарна. Суурь бүтцийн тухай энэ үзэл санаа түүний үзлийг уламжлалт нийгмийн гэрээний онолоос ялгаж байгаа юм. Учир нь тэрбээр “нэгэнт л нийгмийн гэрээнд оролцогч талуудыг эрх чөлөөтэй, тэгш эрхтэй (рациональ) ёс суртахуунт бие хүн хэмээн үздэг юм бол суурь бүтцийг анхдагч судлагдахуун болгох хатуу чанд шалтгаан болох ёстой” (Ж.Роулс, 2016, хууд. 195) гэсэн байна. Эндээс тэрээр суурь бүтцээс эхлээд шударга ёс болсон зүй ёсонд өвөрмөц шинжийг олгож байдаг бусад зарчим байнга хөгжиж байдаг гэсэн

ажээ. Үүнийхээ үндэслэл болгож тэрээр утилитаризмын үүднээс тайлбар хийсэн байна. Тухайлбал утилитаризмын төлөөлөгч Бентам, хувь хүн шийдвэр гаргахдаа ямар үйл ажиллагааг зөв хэмээн тооцоолох зарчмыг гаргаж ирдэгт холбогддог. Энэ баримтлал ёсоор тухайн үйлдэл хэдийд зөв, хэдийд буруу байхыг тогтооход хэрэглэх объектив зарчим байх ёстой бөгөөд энэхүү шалгуурыг “ашиг тусын зарчим” гэдэг. Бентам ашигт чанарын зарчмыг Англи дахь анги-давхрааны ялгаварт байдал, уламжлал, хууль, язгууртны эрх мэдлийг довтлох зэвсэг хэмээн итгэж байв (Вольф Р. П., 2021, хууд. 270). Ашигт чанарын зарчим нийгмийн бүх хэлбэр болон хувь хүний үйл ажиллагаанд ижил ханддаг; нэмж хэлэхэд, зан чанар, төрх байдал түүнчлэн магтах, зэмлэх зэрэг нийгмийн практик үүгээр жолоодуулж байдаг.

Утилитари онол мэдээж, янз бүрийн тохиолдлын өвөрмөц шинжийг хүлээн зөвшөөрнө. Гэхдээ энэ шинжүүд зөвшөөрөгдөх ёстой янз бүрийн үр дүн, шалтгаант холбооноос үүсдэг. Тэгэхээр суурь бүтэц нь нийгэм, психологийн гүнзгий, өргөн хүрээт мөн чанартай бөгөөд байгууллагуудын чухал нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж болно. Мөн өвөрмөц шинжүүд нь тухайн бүтцийг дотоодын байгууллагуудаас төдийгүй хүрээлэн буй олон улсын системээс ч ялгаж өгдөг. Энэ ялгаа ашигт чанарын хэм хэмжээнд ч системт маягаар хандахад тусаж болох юм. Гэхдээ хэдийгээр ашигт чанараас гарсан янз бүрийн хэм хэмжээ, дүрэм журам өөр, өөр асуудлын үндсэн шинжийн тухай үзлээр тодорхойлогдох нь мэдээж боловч анхдагч зарчим өөрчлөгддөг тохиолдол байхгүй. Тэгэхээр утилитари үзэл нь хэчнээн олуулаа байдаг ч гэсэн хувь хүмүүс болон шийдвэр, үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллагын хэлбэрт анхаардаггүй, харин ашигт чанарын зарчмын түгээмэл хүрээнд л нөлөөлнө: энэ үзлээр тоо, бүтэц хоёр маш их сэтгэл ханамж бий болоод шууд бус

нөлөөлөх үед л холбогддог гэжээ (Ж.Роулс, 2016, хууд. 196).

Мөн тэрээр бичихдээ, шударга ёс болсон зүй ёсонд суурь бүтцийн байгууллагууд хүмүүсийн хоорондох шударга нөхцөлд эрх чөлөөтэй, тэгш эрхтэй, ёс суртахуунлаг бие хүний зарчмыг хангаж, энэ бүтцээ журамлах зорилгоор тодорхой зарчмуудыг хүлээн авдаг гэсэн. Энэ нь: а. Хүн бүр бусдад ч таарч зохицсон суурь эрх чөлөөний өргөтгөсөн схемийг эзэмших тэгш эрхтэй. б. Нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг дараах нөхцөлд л зөвшөөрч болох юм гээд: I. Хамгийн эмзэг бүлгийнхэнд хамгийн ашигтай туслах, II. Албан тушаал, эрх мэдлийн бололцоо ямар ч нөхцөлд бүх хүнд шударга, тэгш байдлаар нээлттэй байх тухай хэмээсэн байдаг (Ж.Роулс, 2016, хууд. 202). Тэрээр суурь бүтцийн үүргийг анхны гэрээ-хэлцлийн нөхцөлийг тодорхойлоход чухал гэж үзсэн байна. Роулс анхдагч байдалд байгаа хүмүүс зүй ёсны зарчмаа утилитаризмаас илүүтэй гэж үзэн сонгодог гэсэн юм.

Роулс бодгалийг засгийн газрын дарангуйллаас хамгаалж болдог эрх чөлөөний суурь шинж чанарыг ойлгоход тэрээр Милльтэй санал нийлдэг. Гэхдээ Роулс эдгээр эрх чөлөө нь улс төрийн зарчим болохын хувьд эцсийн дүндээ аль болох олон хүнд хамгийн сайхан аз жаргалыг хангах ёстой гэдэг үндсэн дээр эдгээр эрх чөлөөг хамгаалах гэж оролддоггүй. Харин утилитаризмд шударга нийгэмд нийцэшгүй зарим тал бий хэмээн үзэж байсан. Жишээлбэл, гэмгүй хүмүүсийг шийтгэх нь хэрэв ирээдүйд хуульд харш зан байдлыг сэргийлэх үр ашигтай арга мөн гэдэг нь тодорхой байхад ямар ч хорон санаат үйлдэл хийсэн гэх буруугүй хүмүүсийг нийгэм ухамсартайгаар шийтгэж болдог гэж утилитаризмын зарчмаас үзвэл зохино. Роулсын бодлоор, энэ нь ашиг тусын зарчмын үр дагавар мөн боловч тийм үндэслэл нь гэмгүй мөрөөрөө нэг ч хүн нийгмийн

амьдралыг зохицуулдаг хуулиудын мэдээжийн золиос болох ёсгүй гэж үздэг шударга ёсны суурь зарчмыг зөрчдөг. Роулс нийгмийн сайн сайхан байдлыг хангах учиртай ардчиллын хэлбэрийг хамгаалдаг болохоор өмчийн эрхийн тэргүүлэх байдлын талыг баримтлагч, утилитаризмыг баримтлагч ч биш юм.

Тэгэхээр Роулс өөрийн үзэлд хувь хүний эрх чөлөө, засгийн газрын хязгаарлагдмал эрх мэдэл, нийгмийн гэрээний асуудлыг утилитаризмаас уламжилж авсан ч ийнхүү утилитари зарчимд хамаарах сул талыг тодотгон уг үзэлд шүүмжлэлтэй хандсан байна.

### **Ном зүй**

1. Вольф, Р. П. (2021). Философийн тухай.
2. Нийгэм-улс төрийн философийн орчин үеийн онолууд. (2023).
3. Ж.Роулс. (2016). Улс төрийн либерализм.
4. М.Сандел. (2018). Шударга ёс зөв зүйл гэж юу вэ?
5. Улс төр судлал 30 секундэд. (2016).
6. Bird, C. (2006). An Introduction to Political Philosophy. Cambridge University Press.
7. Edward, T. R. (2016). Rawls versus Utilitarianism: the subset objection. Journal of Philosophy, 37-41
8. Labukt, I. (2009). Rawles on the practicability of Utilitarianism. Politics, Philosophy and Economics, 139-243.
9. Lyons, D. (1972). Rawles Versus Utilitarianism. The Journal of Philosophy, 535-545.
10. Rawls, J. (1999). Theory of Justice. Harvard University Press.
11. S.Wenz, P. (2007). Political Philosophies in Moral conflict. McGraw Hill.

### **Abstract:**

In this article, the authors compare various ideas regarding the concept of justice. Authors analyze the principles of the theory of justice, elucidate how John Rawls's views relate to ethics, and clarify the concept of justice as well as the ethical foundations of political philosophy. The article also discusses Rawls's critique of traditional utilitarian philosophy and how he constructs his theory of justice.